

24

ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр

№1

Улаанбаатар хот

Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, “Хөвсгөл алтан дуулга” Хувьцаат Компанийн дүрмийн 7.8.3 дахь заалт, 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл алтан дуулга” Хувьцаат Компанийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Н.ЕРӨӨГЭРЭЛ

30

ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр

№2

Улаанбаатар хот

Компани нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох, Төлөөлөн удирдах зөвлөлд зарим бүрэн эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,3,8 дахь заалт, “Хөвсгөл алтан дуулга” Хувьцаат компанийн дүрмийн 7.7.1, 7.7.3, 7.8.2, 7.8.8 дахь заалтыг удирдлага болгон 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1.“Хөвсгөл алтан дуулга” ХК нь дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх, компанийн санхүүгийн чадавхийг сайжруулах, гурилын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр компанийн үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтыг босгох зорилгоор 4,405,600 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгон нэмж гаргасугай.


2.“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хувьцаа нэмж гаргах төслийг хавсралт 1-р баталсугай.

3.“Хөвсгөл алтан дуулга” ХК -ийн нэмж гаргаж буй хувьцаа нь компанийн хувьд их хэмжээний хэлцэлд тооцогдож буй тул хувьцааг эргүүлэн худалдан авах үнийг тогтоох, нэмж гаргаж буй хувьцааны нийтэд санал болгох үнэ, нэмж гаргах хувьцаатай холбоотой асуудлуудад тухай бүр шуурхай шийдвэр гаргах бүрэн эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.

4.“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж хувьцаа гаргах, нэмж гаргаж буй хувьцааг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэхтэй холбоотой мэргэжлийн байгууллагуудтай харилцах ажлыг шуурхай зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Д.Дуламсүрэн/-д үүрэг болгосугай.

5.Нэмж гаргасан хувьцааг олон нийтэд санал болгон амжилттай болсон тохиолдолд дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг 2019 онд боловсруулан, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Н.ЕРӨӨГЭРЭЛ

**ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр

№3

Улаанбаатар хот

***Компанийн нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн
ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй
байх тухай***

Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт, “Хөвсгөл алтан дуулга” Хувьцаат компанийн дүрмийн 7.8.2 дахь заалтыг удирдлага болгон 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Бүртгэлийн өдрийн байдлаарх “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд тус ХК-иас нэмж гаргаж буй 4,405,600 ширхэг хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Н.ЕРӨӨГЭРЭЛ

ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр

№ 4

Улаанбаатар хот

ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.13 дахь заалт, “Хөвсгөл алтан дуулга” Хувьцаат Компанийн дүрмийн 7.8.7-д заасныг үндэслэн 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулал, нэмэгдэл болон Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, хороодын хуралд оролцсон оролцооны нэмэгдлийг шинэчлэн тогтоож, хавсралтаар баталсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тогтмол цалин, урамшуулал, нэмэгдлийг жилийн эцэст, оролцооны нэмэгдлийг тухай бүр олгож байхыг нягтлан бодогч Н.Одончимэгт зөвшөөрсүгэй.


3. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын цалинг сарын 600000 төгрөгөөр тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА



Н.ЕРӨӨГЭРЭЛ

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2018 оны
4 дүгээр сарын 02-ны өдрийн ХЭХ-ын
4 тоот тогтоолын хавсралт



**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ,
НЭМЭГДЛИЙН ХЭМЖЭЭ**

ТУЗ-ийн гишүүдийн цалин, нэмэгдэл		Хэмжээ, холбогдох татвар шимтгэлийг суутгасан байдлаар /төг/
Сард олгох тогтмол цалин ба нэмэгдэл	Хараат гишүүд	50,000
	Хараат бус гишүүд	70,000
	Хороодын даргын нэмэгдэл	30,000
	ТУЗ-ийн даргын нэмэгдэл	30,000
Оролцоонд үндэслэсэн нэмэгдэл	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон тоогоор	50,000

**ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр

№ 5

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.1-д заасныг үндэслэн “Хөвсгөл Алтан дуулга” ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, компанийн дүрмийн эхийг хавсралтаар баталгаажуулсугай

2. Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, хувийг 14 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Д.Дуламсүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Н.ЕРӨӨГЭРЭЛ